



ТӨВ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

41111 Төв аймаг, Зуунмод сум,  
Утас: 70273623, Факс: 70272237

*Бэлд. 12.13* № *05/2020*

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагын 2022 оны 12 дугаар сарын  
08-ны өдрийн 01/441 тоот албан бичгийн хариуг  
хүргүүлж байна.

Хавсралт 1 хуудастай.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ХЭЛТСИЙН  
ДАРГА *[Signature]* Ю.БЯМБАЦОГТ



4322022137

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН  
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ТАЙЛАНГААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2022.12.12

Зуунмод

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	<p>Аймгийн Засаг даргын ерөнхий данснаас улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлдэг байдлыг таслан зогсоож, тус дансны санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах</p>	<p>Аймгийн төсвийн ерөнхийлөн бөгөөд Засаг дарга нь төсөв, санхүү, бүртгэлийн чиглэлээр Төсвийн тухай хуулиар 12 бүрэн эрх, 20 чиг үүрэг, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар ерөнхий 16 чиг үүрэг, тусгайлсан 23 чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг. Мөн салбарын бусад хуулиудаар 50 гаруй үүрэг эрхийг хүлээдэг. Мөн Монгол улсын Засгийн газар, түүний салбарын сайд нартай хамтран ажиллах санхүүжилтийн гэрээ байгуулан ажиллаж байна. Дээрх хуулиудаар хүлээсэн чиг үүрэг, бүрэн эрх, үүргийн хүрээнд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг улс, орон нутгийн төсөвт байгууллагуудын үйл ажиллагааг удирдан чиглүүлж ажилладаг.</p> <p>Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны 2000-2024 он хөтөлбөр, жил бүрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллахад энэхүү ерөнхий данснаас санхүүжилтүүдийг гарган ажиллаж ирлээ.</p> <p>2022 онд аймгийн Засаг даргын ерөнхий дансны хуваарилагдаагүй зардалд 945,7 сая төгрөгийг төлөвлөн зарцуулсан болно. Дансны сар, улирлын гүйцэтгэлийг гарган, хэрэгжилтийг хангаж санхүүгийн сар, улирлын тайлан, мэдээнд тусган тайлагнаж байна.</p>
2	<p>Шилэн дансны цахим хуудасанд байршуулах мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, иж бүрэн олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж хэвших</p>	<p>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах чиглэлээр сум, төсөвт байгууллагуудын шилэн дансны сар, улирал бүрийн хэрэгжилтэд Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын хэлтсээрээ хяналт тавиулан, хэрэгжилтийг хагас бүтэн жилээр дүгнэн, сум, хэлтэс, агентлаг дүгнэх Засаг даргын үзлэгийн удирдамжид оруулан дүгнэж байна.</p> <p>Цахим дансны мэдээллийг олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулах чиглэл өгч ажилласнаар шилэн дансны хөтлөлтийн явц 2022</p>

		<p>оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 281 байгууллага шилэн дансны мэдээлэлд байршуулбал зохих 33,293 мэдээллээс 31,774 мэдээлэл байршуулж, аймгийн хэмжээнд хэрэгжилт 94.3 хувьтай байна.</p> <p>2022 онд Сангийн яамнаас шилэн дансны нэгдсэн системийг төрийн сангийн цахим шинэчлэлттэй уялдуулан хялбаршүүлсэн энгийн болгох ажлыг хийж, 2023 оны 1сарын 01-ний өдрөөс эхлэн шилэн дансны мэдээллийн шинэчилсэн хэлбэрт оруулахаар ажиллаж байна.</p>
--	--	--

Хэрэгжилтийг хянасан:

Санхүү төрийн сангийн хэлтсийн  
дарга Ю.Бямбацогт

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАНГИЙН ӨГӨГДСӨН ЗӨВЛӨМЖИЙН БИЕЛЭЛТ

2022.12.12

Зуунмод

№	Зөвлөмжийн утга	Хэрэгжилт
1	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрөл бүрээр жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч, гүйцэтгэлийн явцад дүн шинжилгээ хийж, хяналт тавин ажиллах	2022 оны эхэнд аймгийн Засаг даргын А/49 тоот захирамжаар аймаг, сумын төсөвт төвлөрүүлэх орлогын сар, улирлын хуваарийг гарган хүргүүлж, хэрэгжилт биелэлтийг Татварын хэлтсээр сар бүр гаргуулан, хяналт тавин ажилласан. Аймгийн Засаг дарга, сумын Засаг даргатай байгуулсан Засгийн газрын зарим чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд аймаг, сумын төсвийн орлогын төлөвлөгөөг сар, улирал бүр жигд ханган биелүүлж байх заалт оруулан хэрэгжилтийг улирал бүр хянан ажилласан. Төсөвт тодотгол хийсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/625 тоот захирамжаар хуваарийг шинэчилсэн. Хүлээгдэж буй гүйцэтгэлээр сумын төсвийн орлого 115,7 хувийн биелэлттэй, аймгийн төвлөрсөн төсвийн орлого 119,1 хувийн биелэлттэй байхаар тооцогдож байна.хүлээгпэж буй гүйцэтгэлээр орлогын нэр төрлийн хувьд сумын төсвийн орлогоос 6 нэр төрлийн, аймгийн төсвийн орлогоос 2 нэр төрлийн орлого тасарч байна.
2	Үр дүнд чиглэсэн хөтөлбөр төлөвлөлтийг хэрэгжүүлэхийн тулд хөтөлбөрийн хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн иж бүрэн тодорхой болгох	Аймаг нийслэл сум дүүргийн 2023 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг тодорхой болгох, чанар үзүүлэлтийг сайжруулах хүрээнд Сангийн сайдаас ирүүлсэн орон нутгийн 2023 оны төсвийн төслийг боловсруулах, хэлэлцэн батлах, хэрэгжүүлэхэд баримтлах чиглэл, удирдамжийн хавсралтаар ирүүлсэн аргачлалын дагуу боловсруулж, аймгийн ИТХ-ын Арвангуравдугаар хуралдааны 02 тоот тогтоолоор батлууллаа.
3	Сумдын ИТХ-аар батлагдсан төсвийн дагуу FISCAL-B программд оруулж ИТХ-ын тогтоолоос	Сумын төсөв, орон нутгийн төсөвт байгууллагуудын төсвийг төсвийн төлөвлөлтийн fiscal программд эдийн засгийн ангилал,

	зөрүүтэй тайлагнаж байгаа зөрчлийг давтан гаргахгүй байх	хөтөлбөрөөр нь ангилан оруулж, сар улирлын зарлагын хуваарийн дагуу зарцуулан тайлагнаж байна. Сумын ИТХ-ын баталсан тогтоол зөрүүтэй эсэхийг тулган баталгаажуулж, зөрүүг арилган нэгтгэж байна.
--	--	--

Хэрэгжилтийг хянасан:

Санхүү төрийн сангийн хэлтсийн  
дарга Ю.Бямбацогт